

Е.И.КЫЧАНОВ

**ЕРТӨНЦИЙГ ЭЗЭГНЭН
ДАГУУЛСАН ТЭМҮЖИНИЙ
ҮЙЛ АМЬДРАЛ**

Орчуулсан Чойнзонгийн Баатар

Хянан тохиолдуулсан

Намсрайн Ням-Осор
Сандуйжавын Одхүү

Улаанбаатар - 2000



Чингис хаан
ЦУВРАЛ-2

Монгол Улсын Ерөнхийлөгч
Нацагийн Багабандийн 1999 оны
11-р сарын 12-ны өдрийн
Захирамжийн дагуу хэвлүүлэв.

ГАРЧИГ

• Хянан тохиолдуулагчдын өмнөх үг	4
• Удиртгал	7
• Өэлүн Үжин, Есүхэй баатар хоёр	11
• “Орь танигдаж мэдэгдээгүй харь холын ард түмэн”...	17
• “Цээлийн ус ширгэв, цэгээн чулуу хагарав”	29
• “Эрсэн хүнээ олсон”	41
• Өөрийн гэсэн улс иргэн	45
• Андууд-дайснууд	52
• Эцгийнхээ өшөөг авсан нь	62
• Тал нутгийн эзэн хэн болох юм бэ, тэгээд?	68
• Их хурилдай	80
• Тангад орны эд баялаг	89
• Хөхөчү бөө	98
• Амбагай хааны гэрээслэлийн биелэлт	103
• Отрарт болсон сүйрэл	112
• Чингис хааны үхэл	128
• Чингис хаан ба түүний үлдээсэн өв	137
• Орос хэлээр хэвлэгдсэн эх сурвалж, ном зохиолын товч жагсаалт	149

Чингис хааны дэрэмжит “Их засаг” дээд сургууль
энэ номыг ивээн тэтгэж хэвлүүлэв.

ХЯНАН ТОХИОЛДУУЛАГЧДЫН ӨМНӨХ ҮГ

Хүн төрөлхтний нийтлэг тооллын хоёр дахь мянганд “дэлхийд хамгийн алдаршсан хүн”-ээр тодорсон, монголчууд бидний бахархал болсон Богд Чингис хааны тухай Е.И.Кычановын энэхүү номыг оросоос монгол хэлнээ орчуулан эрхэм уншигч Тачы гар дээр хүргэж байна.

Тэмүжин нэртэй ч Чингис алдраар ертөнц дахинаа дуурссан энэ Их хүний амьдрал, үйлсийн тухай өгүүлсэн энэхүү бүтээл манай мэргэн уншигчдад таашаагдана буй заа.

Үндэсний ухамсар сэргэж, өнгөрсөн түүхээ сонирхон судлах болсон энэ цаг үед Монгол улсын төрийн тэргүүн шийдвэр гаргаж, Чингис хаан болон монгол судлалын сэдвээр гадаадын эрдэмтдийн туурвисан бүтээлүүдээс монгол хэл рүү орчуулан ботилон хэвлүүлэх ажлыг ивээлдээ авахаа мэдэгдсэн нь энэ ном уншигчдад хүрэхэд түлхэц болсныг өгүүлэхийн ялдамд “Манай Монгол” сэтгүүлийн редакцияас эрхлэн бэлтгүүллээ.

Е.И.Кычановын энэхүү бүтээлийн ололттой сайн тал нь монгол, хятад, бас лалын шашинт Перс мэт улс орнуудын бичгийн хүмүүсийн тухайн үедээ бичиж үлдээсэн, эдүгээг хүртэл хадгалагдаж ирсэн түүхийн эх сурвалжууд, судар шастир, Европын жуулчдын аян замын тэмдэглэл, баримт сэлтэд тулгуурлан Тэмүжиний амьдрал, үйл хэргийг шинжлэх ухааны үндэстэй гаргаж тавихыг зорьсонд оршино. Энэ талаар зохиолч өөрөө номын “Удиртгал”-даа дэлгэрэнгүй өгүүлснээс гадна, номын агуулга зохиогчийн санааг сайтар тодорхойлж байна.

Номын бас нэг давуу тал нь үйл явдлыг энгийн ойлгомжтой

хэлбэрээр, ухааран хүлээж авахад хялбар байдлаар илэрхийлсэн бичлэгийн чадвар юм. Энэ бүтээлийг “Тал нутгийн тансаг үнэр нэвт шингэсэн” /Б.Я.Владимирцов/ “Монголын нууц товчоо” хөлгөн их шаштирын хялбаршуулсан тайлбар гэж үзэж болох талтай.

Монголчууд дэлхий дахины түүхэнд гүнзгий ул мөр үлдээж, хүн төрөлхтний түүхэн хөгжлийн үйл явцад ихээхэн нөлөө үзүүлсэн билээ. Ертөнц бараг бүхэлдээ нойрмог байсан ХП-ХШ зуунд монголчууд морьдоо унан тив, дэлхийг донсолгон сэрээж явсныг түүх гэрчилнэ.

Чингис хааныг сүүлчийн мянган жилийн хамгийн их алдартай хүнээр тодруулсан “Вашингтон пост” сонин “Өнгөрсөн мянган жилд гарсан хамгийн том үйл явдал бол нэг л үндэстэн дэлхий даяар сүр хүчээ бүрэн төгс илтгэж чадсан явдал” гэдгийг онцгойлон тэмдэглэсэн нь монголчууд бидэнд өгсөн том үнэлгээ юм.

Зохиол дахь шинэлэг гэмээр нэг санаа бол Е.И.Кычановын гярхай ажиглаж, зоригтой мэдэгдсэнээр Тэмүжин өөрөө дэлхийг байлдан дагуулах, эзлэн түрэмгийлэхийг хүсээгүй байсан байж болох юм гэдэгт оршино.

Түүхэнд Чингис хааны гүйцэтгэсэн үүргийг үнэн зөв, бодитой үнэлэхэд Е.И.Кычановын ном хүндтэй байр суурь эзлэхээр болжээ. Зохиогч бүтээлдээ Чингис хааныг ердөө л алан хядагч, байлдагч дагуулагч, хэрцгий догшин нэгэн байсан мэт дүрсэлдэг өрөөстөл хандлагаас зайлсхийж, түүний амьдрал, үйл хэргийг нь цаг үе, нөхцөл байдалтай нь холбон авч үзэж тархай бутархай байсан монгол овог, аймгуудыг төдийгүй, салан тусгаар улс гүрэн, ард түмнүүдийг нэгтгэх, төвлөрүүлэхэд үнэлж баршгүй үүрэг гүйцэтгэснийг зүй ёсоор үнэлжээ. Үзэл суртлын нөлөө хүчтэй байсан 30-аад жилийн тэртээ Чингис хааны гүйцэтгэсэн үүргийг ийнхүү эерэгээр үнэлсэн нь чухал ололт байв.

Солонгосын нэрт сэтгүүлч Ким Жон Рэ “Мянган жилийн

түүхэн хүн” хэмээх номондоо;

“Чингисийн үеийн монголын хурд, эрч хүч бол аливаа хямралаас гарах, ер нь хөгжил дэвшилд хүрэхийн үндсийн үндэс гэж өдгөө дэлхий дахин үзэх боллоо” гэсэн санаа Е.И.Кычановын үнэлгээтэй холбоотой байна.

Е.И.Кычановын номд тусгагдсан эзэн Чингис хааны амьдрал, үйл ажиллагаа өнөөгийн бидэнд нэгийг бодогдуулж, сургамж ухаарал хайрлах болно.

Түүхийн ухаан дэд доктор

Намсрайн НИЯМ-ОСОР

Философийн ухааны дэд доктор

Сандуйжавын ОДХҮҮ

2000 оны I сар

Чингис баруун гартаа шагайн
чинээ нөж атган төржээ.

“Монголын нууц товчоо”

УДИРТГАЛ

Буурал түүхийн олон зууны туршид даян дэлхийн улс орон бүрийн түүхч-мэргэжилтнүүдийн болон өргөн олон уншигч түмний анхаарлыг Чингис хаан, түүний амьдарч байсан эрин цаг татсаар өдгөө болжээ. Түүнд зориулсан шинжлэх ухааны дорвитой бүтээлүүд бий болж, эрдэм шинжилгээний хялбаршуулсан ном, товхимлууд гарч, өргөн баялаг үйл явдал, утга агуулгатай роман туужууд ч бичигдэн, дэлхийн олон олон улс оронд хэвлэгдсээр ирлээ. Энэхүү байлдан дагуулагчийн хувь хүний нь шинж төрх, зан чанар, онцлогийг олж мэдэж, онож тодорхойлох гэсэн сонирхол эрмэлзэл сүүлийн үед улам ч хүчтэй болов. Чингис хааны тухай шинжлэх ухааны хялбаршуулсан хэд хэдэн бүтээл өрнөдөд гарсны заримыг дурдвал: Францад Морис Першероны “Чингис хаан” /1962/; Х.Ламбагийн “Тал нутгийг эзэгнэгч Чингис хаан” /1966/; АНУ-д Маккензигийн “Далай тэнгис ба тал нутаг. Монголын байлдан дагуулагч Чингис хааны үйл амьдрал ба эрин үе нь (1155-1227)” /1963/; Дюпюигийн “Чингис хаан” /1970/ зэрэг номууд болно. Унгар, Чехословакт ч Чингис хааны тухай шинжлэх ухааны хялбаршуулсан номууд гарав. Сүүлийн жилүүдэд, академич Б.Я.Владимирцовын “Чингис хаан” хэмээх ном англи, франц хэлээр хэд дахин хэвлэгдлээ.¹

Харин өнөөгийн Орос орны уншигчид Чингис хаан, түүний эрин үеийн тухай түүхийн сурвалжуудад тулгуурлаж, хялбаршуулсан байдлаар бичигдсэн мэдээ сэлтийг олж авах бололцоогүй байгаа нь харамсалтай.² Оросын гарамгай эрдэмтэн, монгол судлаач, академич Б.Я.Владимирцовын бичиж, 1922 онд Берлинд хэвлүүлсэн, маш

1. Дэлхийн олон олон улс оронд Чингисийн тухай, тэр үеийн монголчууд, тэдний амьдрал тэмцлийн тухай янз бүрийн хэлээр эрт, эдүгээд гарсан маш олон ном зохиол байдгаас эрдэмтэн Е.Кычанов зөвхөн хэдхэнийг нь энд дурджээ. /Орчуулагч/
2. Зохиогч энэ товхимол хийгээд түүнд зориулсан удиртгалаа 70-аад оны эхэн үеэр бичиж хэвлүүлснийг уншигчиддаа тодруулан сануулья. /Орчуулагч/.